



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/406

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн нийтээр дагаж мөрдөх журам болон аймгийн Засаг даргын “Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаагаар хориглох тухай” захирамжийг хэрэгжүүлж ажиллаагүй аж ахуйн нэгжүүдэд сонсох ажиллагаа зохион байгуулах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтнийг томилсугай.

2. Сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу хийж гарсан саналыг тухай бүрт танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ